ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

НЭГ. Товч танилцуулга[2]

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын статистикийн мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд хүргэх үүрэгтэй Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага юм. Тус хороо нь төв байгууллага болон Нийслэлийн статистикийн газар, 9 дүүрэг, 21 аймгийн статистикийн хэлтэстэй бөгөөд салбарын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар бүтцээр 320 албан хаагч, үүнээс төрийн захиргааны 294, төрийн үйлчилгээ 26 албан хаагч ажиллаж байна. Үндэсний статистикийн хорооны даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар Үндэсний статистикийн хорооны дэргэдэх Ёс зүйн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй, Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Нийслэлийн статистикийн газрын дэргэдэх Ёс зүйн хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулж, салбарын нийт албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Үндэсний статистикийн хорооны Ёс зүйн дэд хороо нь үйл ажиллагааны чиглэлээр 5 дэд бүлгийн 12 ажил, сургалтын чиглэлээр 3 дэд бүлгийн хүрээнд 6 сургалтын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж ажилласан.

- Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд Ёс зүйн хорооны “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” 2024 оны 15 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан агуулгын хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:
    - Монголын Хүний нөөцийн институттэй хамтран Байгууллагын соёл, байгууллагын ёс зүй сургалтыг 2025 оны 03 дугаар сард зохион байгуулж, Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсийн нийт 181 албан хаагчийг хамруулсан;
    - Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомжийн талаарх сургалтыг Ёс зүйн хороотой хамтран танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж 280 гаруй албан хаагчийг хамруулсан;
    - Мөн Үндэсний статистикийн хороонд шинээр орж ажиллаж буй албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, түүнийг мөрдөх төрийн албан хаагчийн үүрэг” сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 24 албан хаагчийг хамруулсан;
    - Албан хаагчдын ажлын байрны ёс зүйн төлөвшил, стрессийг бууруулах, урам түгээх, хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хувь хүний хөгжлийн сургагч багш Т.Азбаяр “Урам түгээе, ёс зүйтэй төрийн албан хаагч” сэдвээр сургалт зохион байгуулж, нийслэл, дүүргийн 47 албан хаагчийг хамруулсан.

- Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2025 оны 12 дугаар сард хамт олны дунд ёс зүйтэй, эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор “Талархъя, Уучилъя, Магтъя” 3 хоногийн нөлөөллийн аяныг зохион байгуулж, нийт Үндэсний статистикийн хорооны төв байгууллагын 123 албан хаагчийг хамруулсан.

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана

- Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын дагуу салбарын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийхээр төлөвлөж, "маш өндөр" болон "өндөр" түвшинд үнэлэгдсэн албан хаагчдаас Ёс зүйн хорооны 2025 оны 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг"-ийг гаргуулж авах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, бууруулах чиглэлээр нөлөөллийн аян зохион байгуулсан;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын хүрээнд "Ажлын байрны дарамтын талаарх судалгаа"-г 2025 оны эхний хагас жилд 198, сүүлийн хагас жилд 204 албан хаагчийг хамруулан зохион байгуулж, үр дүнг албан хаагчдад танилцуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

- Ёс зүйн дэд хорооны 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дүгнэлтийг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтан буюу Үндэсний статистикийн хорооны даргын 2025 оны Б/13 дугаар тушаал гарч нэг удирдах албан тушаалтанд "Ёс зүйн хариуцлага хүлээлгэж, хамт олны өмнө уучлалт гуйхыг үүрэг болгосон байна;
- Төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр, үйл ажиллагааны тайланг www.nso.mn сайтын ил тод байдлын Ёс зүйн дэд хороо хэсэгт байршуулж ажилласан;
- Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшууллыг тухай бүр олгож байгаа бөгөөд 2025 оны 4 дүгээр улирлын урамшууллыг Сангийн яамнаас программын эрх хаасантай холбоотойгоор олгоогүй байна. 2026 онд урамшууллыг бүрэн олгохоор санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

- Ёс зүйн хорооны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалтын дагуу Ёс зүйн дэд хороонд орсон өөрчлөлтийг тухай бүр байгууллагын www.nso.mn сайтын ил тод байдлын Ёс зүйн дэд хороо хэсэгт шинэчилж байна;
- Зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах чиг үүргийн хувьд 2025 оны байдлаар нийт 5 гомдол ирсэн бөгөөд 1 зөрчилд хариуцлага тооцож, 3 гомдолд зөрчил тогтоогдоогүй, 1 зөрчлийг харьяалах бусад байгууллагад шилжүүлж ажилласан;
- Дэд хорооны ажлын төлөвлөгөө, биелэлт, тайланг хугацаанд нь мэдээллийн цахим санд байршуулсан. Мөн ёс зүйн талаар гарсан гомдол, мэдээлэл, холбогдох баримт болон гомдлыг хянан шийдвэрлэсэн дүгнэлт, томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг тухай бүр цахим санд бүртгэж ажилласан.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
• Дэд хорооны гишүүд чадавхжиж байна; • Албан хаагчдын дунд эерэг уур амьсгал бүрдэж байна; • Албан хаагчдын ёс зүйн талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл дээшилсэн.	• Дэд хорооны гишүүд нь шинээр томилогдсон тул зарим асуудлыг шийдвэрлэх, хууль журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахад хуулийн болон бусад мэдлэг дутмаг байсан нь хүндрэлтэй байсан.
Санал:	
Ёс зүйн хорооноос гарч буй аливаа тогтоол, журам, заавар аргачлалыг хэрхэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаарх заавар зөвлөмжийг тогтмол өгч байх.	

Шалгах хэсэг:

- ☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

/Албан тушаал/	/Гарын үсэг/	/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

/Албан тушаал/	/Гарын үсэг/	/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/Албан тушаал/	/Гарын үсэг/	/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	0.8	8
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.5	5
Хэсгийн оноо				**4**		**23**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**		**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**		30
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**		**83**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний
[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх
[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг
[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт
[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн
[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн

-oOo-

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Г.ЯЛАЛТ
2025 оны 02 дугаар сарын 28

УХА0581 6007465

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

№	Арга хэмжээний нэр	Агуулга	Хугацаа (улирал) I	II	III	IV	Хариуцах гишүүн
1	2	3	7				8
Нэг. Үйл ажиллагаа							
1	Ёс зүйн байдлыг тогтоох судалгаа хийх	Ажлын байрны дарамтын талаарх судалгааг зохион байгуулж, үр дүнг албан хаагчдад танилцуулна.					Ёс зүйн дэд хорооны гишүүн Л.Ундрал, О.Норовсамбуу
		Байгууллагын хэмжээнд гарч буй болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлнэ.					Ёс зүйн дэд хорооны гишүүн Б.Анхзаяа, С.Норов
2	Талархлын хайрцаг ажлуулах	Эерэг таатай хандлага байгууллагын орчинд бий болгох зорилго бүхий талархлын хайрцаг 14 хоногийн хугацаатай ажлуулна.					Ёс зүйн дэд хорооны дарга Г.Ялалт, гишүүн Д.Буманбаяр
3	Тодорхой сэдвээр аян зохион байгуулах	Төрийн албаны ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагыг товч, тодорхой, ойлгомжтой хэлбэрээр ангилан төрөлжүүлж, ёс зүйн тайлбар, гарын авлага, зөвлөмж, зааврыг бэлтгэн албан хаагчид түгээх, сурталчлах, мэдээлэх ажлыг хийнэ.					Ёс зүйн дэд хорооны гишүүн Б.Анхзаяа, С.Норов
4	Ёс зүйн асуудлаар санал асуулга зохион байгуулах	Албан хаагчдын ёс зүйн тухай ойлголтыг судлан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг хэрхэн дагаж мөрдөж буйг илрүүлж, ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах зорилготой судалгааг зохион байгуулж, үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулж, дараа жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.					Ёс зүйн дэд хорооны гишүүн Л.Ундрал, О.Норовсамбуу
5	Бусад	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулна.					Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
		Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайлан, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын удирдлага болон албан хаагчдад танилцуулна.					Ёс зүйн дэд хорооны дарга
		Ёс зүйн дэд хорооны ээлжит хурлыг улирал бүр хийж, төлөвлөгөөний хэрэгжилт, бусад холбогдох асуудлыг хэлэлцэн, шийдвэрлэж хэвшүүлнэ.					Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийг тухайн байгууллагын ёс зүйн дэд хороо хүлээн авч, цахим санд бүртгэнэ.					Нарийн бичгийн дарга Б.Гоцбаяр
		Ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийн үндэслэлийг шалган тогтоож, хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд хуулийн хугацаанд багтаан дүгнэлт гаргаж, дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.					Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
		Ёс зүйн гомдол, мэдээлэл, гаргасан дүгнэлт, томилох эрх бүхий этгээд зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага тооцсон шийдвэрийг "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийнэ.					Нарийн бичгийн дарга Б.Гоцбаяр
		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг улирал бүр Ёс зүйн хороонд хүргүүлнэ.					Нарийн бичгийн дарга Б.Гоцбаяр
		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тухай амлалтыг бүх албан хаагчдаас авна.					Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
Хоёр. Сургалт							
6	Шинэ албан хаагчдын сургалт	Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага.					Ёс зүйн дэд хорооны дарга Г.Ялалт, гишүүн О.Норовсамбуу
		Төрийн албан хаагчийн ёс зүйн болон сахилгын зөрчил, түүний ялгаа.					Ёс зүйн дэд хорооны дарга Г.Ялалт

		Ашиг сонирхлын зөрчил.					Ёс зүйн дэд хорооны дарга Г.Ялалт
7	Тодорхой бүлэгт хамаарах албан хаагчдад зориулсан сургалт	Ёс **зүйн зөрчлийг шалгах** шийдвэрлэх **чиглэлээр** Ёс зүйн **дэд хорооны гишүүдийг мэргэшүүлэх** сургалтад хамрагдана.					Ёс зүйн дэд хорооны нийт бүрэлдэхүүн
8	**Нийт албан хаагчдын сургалт**	Ажлаас халшрах **хэм шинж.**					Ёс зүйн дэд хорооны гишүүн Б.Анхзаяа
		Төрийн **албаа ба олон нийтийн итгэл.**					Ёс зүйн дэд хорооны гишүүн Д.Буманбаяр